



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/496

Мөрөн сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VI хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, нэрлэсэн жил, ахмад настнаа хүндэтгэх, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хавсралтад заагдсан арга хэмжээнд 89390000 (Наян есөн сая гурван зуун ерэн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Хавсралтад заагдсан 89390000 төгрөгийг Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр баталсан Засаг дарга данснаас гаргахыг аймгийн Ерөнхий санхүүч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр
сарын 27-ны өдрийн А/496 захирамжийн
хавсралт

ХӨРӨНГӨ ГАРГАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Хөрөнгө гаргах зардлын нэр	Хөрөнгийн хэмжээ мянган төгрөг	Ямар байгууллага	Хариуцах хэлтэс
1	Хөл бөмбөгийн дэлхийн аваргын тэмцээнийг Чингүнжавын талбайд Led дэлгэцээр дамжуулах түрээс	14200000	Led мастер Эвэнт ХХК	ТЗУХэлтэс Хэвлэл мэдээллийн мэргэжилтэн
2	Дэлхийн хараагүйчүүдийн Ази Номхон Далайн бүсийн чуулганд оролцох зардал	650000	Аймгийн харааны бэрхшээлтэй иргэдийн холбоо	НБХэлтэс
3	Хөвсгөл аймгийн 99 гайхамшиг фото альбом хийх зардал	2880000	БСУГазар	НБХэлтэс
4	ХДТ –ын уран бүтээлчид Э.Оюуны нэрэмжит Улсын уралдаанд оролцох зардал	1500000	ХДТеатр	НБХэлтэс
5	Соёлын биет болон биет бус өвийн сургалт зохион байгуулах зардал	660000	ОНСМузей	НБХэлтэс
6	Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа	15100000	БСУГазар	НБХэлтэс
7	Нэрлэсэн жилийн ажил ахмад настнаа хүндэтгэх	51300000	Аймгийн ахмадын хороо	НБХэлтэс
8	Багш нарын өдөр, эцэг эхийн чуулганы үйл ажиллагаа	2500000	Хатгал тосгоны ЕБСургууль	НБХэлтэс
9	Соёл урлагийн ажилтны өдөр	600000	Хатгал соёлын төв	НБХэлтэс
	Дүн	89390000		